



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 01 сарын 20 өдөр

Дугаар АЖИ

Хэрлэн сум

Хэлэлцүүлэг зохион байгуулахад  
хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалтууд, Монгол Улсын Их Хурлын даргын 2022 оны 191 дүгээр захирамж, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар шинэчлэн батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын журам”-ын 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Газрын багц хууль, Геодези, зураг зүй, Хот байгуулалтын тухай хуулиудын шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг танилцуулах, санал авах талаар төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн байгууллага, аж ахуйн нэгж, иргэд олон нийтийг хамруулсан хэлэлцүүлэг зохион байгуулах ажилд 2,362,000 (хоёр сая гурван зуун жаран хоёр мянга) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2. Зарцуулах хөрөнгийн тооцоог хавсралтаар баталсугай.

3. Шаардагдах хөрөнгийг Засаг даргын нөөц сангийн нэг удаагийн шинжтэй арга хэмжээний зардлаас санхүүжүүлж, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Ганбаатар)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

Аймгийн Засаг даргын 2022 оны  
01 дугаар сарын 23-ны  
А/41 дугаар захирамжийн хавсралт

Зардлын тооцоо

№	Зардлын нэр	Тоо ширхэг	Үнэ	Нийт дүн
1	Цайны завсарлага	400 хүн	5,200	2,080,000
2	Цэвэр ус	282	1000	282,000
	Нийт			2,362,000